



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/39

Номгон

Г 7

“Монголын Тэмээн соёл” улсын зөвлөгөөн,  
баяр наадамд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/57 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 41 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Монголын Тэмээн соёл” улсын зөвлөгөөн, баяр наадмын үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3.“Монголын Тэмээн соёл” улсын зөвлөгөөн, баяр наадмыг зохион байгуулахад шаардагдах 40.200.000 (Дөчин сая хоёр зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал) -т зөвшөөрсүгэй.

4.Аймгийн Засаг даргын 2024 оны А/06 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, Үндэсний өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



Аймгийн Засаг даргын Тамгын газар, оны 01 дүгээр сарын 25-ны өдөр, А/39 дүгээр захирамжийн хавсралт

МОНГОЛЫН ТЭМЭЭН СОЁЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Үйл ажиллагаа	1 дүгээр байр	2 дугаар байр	3 дугаар байр	4 дүгээр байр	5 дугаар байр	Төсөв
1	Хурдан ат	3000.000	2.500.000	2000.000	1.800.000	1.500.000	10.800.000
2	Өсвөр нас	3000.000	2.500.000	2000.000	1.800.000	1.500.000	10.800.000
3	Хурдан тором	3000.000	2.500.000	2000.000	1.800.000	1.500.000	10.800.000
4	Зориулалт	Тоо ширхэг			Нэгж үнэ	Нийт үнэ	
5	Өргөмжлөл	30			10.000	300.000	
6	6-10 дугаар байрт хурдалсан тэмээний шагнал	15			300.000	4.500.000	
7	11-20 дугаар байрт хурдалсан тэмээний шагнал	30			100.000	3.000.000	
8	НИЙТ ДҮН					40.200.000	

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_